
ДӨРВӨЛЖИН ҮСГИЙН ТОМ ДУРСГАЛ ТОДРОВ

ХАР ХОТООС ОЛДСОН ЭХ БИЧИГ



Сажа нутгийн эрдэмтэн Пагва лам Лодойжалцаны (1235-1280) зохиосон “Шэйжэ равсал шэйжавын данжой ” буюу “Мэдэгдэхүүнийг бэлгэтэеэ гийгүүлэгч нэрт шастир”-ыг монгол хэлээр, монголын дөрвөлжин үсгээр хэвлэсэн нь илэрхий тодорхой болов.

Олз омог болсон жижиг тасархайг хоёр монгол бичмэл эхтэй тулгаж таньсан билээ.

Харин өмнөх үеийн номч өтгөс, эрдэмт лам нар төвд эхээр нь гол төлөв уншиж ашигладаг байсан хийгээд товч нэрээр нь “Шижээ равсал буюу Мэдэгдэхүүнийг сайтар тодруулагч, Мэдэгдэхүүнийг машид гийгүүлэгч” хэмээн орчуулж хэлэлцдэг Монгол нутагт ихэд алдаршсан номын нэг билээ.

- Уул таньж олсон тасархайг монгол бичмэл эхийн тохирох хэсэгтэй тулган мөргүүлж дармал бичмэлийн ялгалаар үзүүлбээс:
- 1….lu’-su ni-gen be-re [bo-lu-yu. e-de]
- *(bo)lbasu nigen bere boluyu: ede*
- 2. ü-li-ge-ri-yer sa-ba yer-tin-ǰü ki-
- *üliger-iyer saba yirtinčü ki=*
- 3. -‘ed a-mi-ta-nu be-ye-sün ča-gi [a-nu]
- *=ged amitan-u beyes-ün čaγ-i (anu)*
- 4. čag-lan ü-lig-de-yü: sa-ba [yer-tin]-
- *čaγlan üligerteyü: saba yirtin=*
- 5. -ǰü bü-tü-kü-yin sil-ta’-[n inü]
- =čü bütükü-yin siltaγan inü
- 6. ten-de tö-rög-čin a-[mi-ta-nu qam]-
- *tende törügčid amitan-u qam=*
- 7. -tu üi-le-düg-sen ǰa-[ya-nu er-ke]-
- *=tu üiledügsen ǰayaγan-u erke-*
- 8. -ber bü-[tü-yü]. b[ü-tü-kü-yin yo-sun]…
- -*ber bütüyü: bütükü-yin yosun…*гэх мэт орчуулжээ.

Мэдэгдэхүүнийг бэлгэтэеэ гийгүүлэгч шастир

Үүнийг одоогийн бичлэгээр буулгавал “... (цагт) болбоос нэгэн бээр болъюу. Эд үлгэрээр сав ертөнц хийгээд амьтны биесийн цагийг цаглан үлгэртъюү. Сав ертөнц бүтэхийн шалтгаан нь тэнд төрөгчид амьтны хамт үйлдсэн заяаны эрхээр бүтъюү. Бүтэхийн ёсон (нь) ...” гэх мэт үгс бүхий өгүүлбэрүүд болой. Ийнхүү тулгахад монгол эх бичгүүдийн орчуулгад үгийн зөрүү байхгүй, үсгийн зөрүү цөөн байгаа нь уг дөрвөлжин бичгийн хийгээд монгол бичгийн тогтсон дүрэмт бичлэгийн онцлогоос болсон хэрэг.

Гараар сэргээсэн байдал

ГАР БИЧМЭЛ	БАР ДАРМАЛ
“...rgyang grags brgyad la ni dpag tshad gcig go/ ’dis ’jig rten dang sems can gyi las kyi tshad gzhal lo// snod kyi ’jig rten gyi khams grub pa’i rkyen ni// der skye bar ’gyur ba’i sems can rnams las mthun par bsags pa’i dbang las so// mngon par grub pa’i tshul ni//” гэжээ.	“...rgyang grags brgyad la ni dpag tshad gcig go/ ’dis ’jig rten dang las kyi tshad rnam par gzhal lo// ’jig rten gyi khams grub pa’i rkyen ni// der skye bar ’gyur ba’i sems can rnams kyis las mthun par bsags pa’i dbang las so// mngon par grub pa’i tshul ni//” хэмээсэн байна.

Үүнийг үзвэл гар бичмэл дэх “**амьтны**” (sems can gyi), “**савын**” (snod kyi) гэсэн үгс бард байхгүй, харин бар дахь “**сайтар**” (rnam par) гэсэн үг хийгээд нугууд хэмээхийн ар дахь “**ын**” (kyi/s/) гэсэн нөхцөл гар бичмэлд байхгүй хийгээд монгол орчуулгын үгс нь гар бичмэлтэй харьцангуй ойролцоо буюу илүү адилавтар байна. Харин хоёр монгол үсгийн бичмэл орчуулгын жишээ авсан зарим үгсийн бичлэг нь хожуу үеийн жигдэрсэн дүрэмт бичлэгээс зөрөөтэй бөгөөд Орос улсад байгаа эх бичигт “bütükü-yin” хэмээх нэг үгийг бичээч андууран давхар хуулсан нь тодорхой байна.

(51a) …
caγan burqan-u mör-i belgetey-e uqaγuluγci:
čary-a avadar radn-a avali suba=sida kiged:
čadigamal mani avali **inǰ-a barakṣ-a** terigüten:
čaγ ügei olan mongγolčilan kele-ten nom-ud-i::
ayalaγu tegüs udqas belgetey-e onuǰu:
ayaγ-qa takimliγ čoski odsiri orčiγuluγsad-i:
anggida anggida qabtasun-dur tamaγ-a čoγuluγsan-i:
amul ügegüy-e tamaγalaγulǰu olan-a tügegülbei::
…
(52e) …
čaγ ügei bodisung nar-un yabudal-i uqaγulqu:
čary-a avadar radn-a avali subasida kiged:
čidigamal mani avali **inǰaba/r/akṣ-a** terigüten:
čaγlabasu ülü bildaqun sastir nom-ud-i::
ayalγu udq-a belgetey-e tegüs medegči:
ayaγ-qa takimliγ čoski odsiri-iyer orčiγulaγulbai:
(53a) anggida anggida tamaγ-a čoγulγaγulǰu tamaγalaγulǰu:
arban ǰüg-tür olan delgere=gülür-ün tügegeǰükü::
…

Өчүүхэн хүн өөрийн чинээгээр уг номыг магтвал тухайн үедээ монголчууд өрнө дорныг холбон торгоны зам, цайны зам дагуу тун их нөлөөтэй аж төрж байсан хийгээд эр цэрэг эдийн засаг, худалдаа арилжаа хууль ёсоор төдийгүй эрдэм ном, соёл гэгээрлийн хувьд ч их том гүрний удирдагч улс байсныг энэ нэгэн ном судар мэт дөрвөлжин үсгийн удаа дараагийн томоохон ном хэвлэл зэрэг нь баталж чадмуй.

Субашидтай харьцуулсан зураг

Шинэ хуудсыг сэргээн тэнхрүүлсэн байдал

“ ...ne-

meg-se-ni-yer **dü-‘ü-rün** bui.:

no-yan kü-‘ün **‘ir-ge-ni** ü-lü qo-ru-

‘u-lan, tö-**rö yo-su**-‘ar al-ba-ni… ” болно.

Дээрх үгсийн утгыг таацаж дүйх монгол орчуулгын хам сэдвээр нь бүрэн үзүүлбэл:

(323) γubčiγdaqun olan-a tula qan-u sang

čögöken-iyer dügürmüi ülemji ülü γubčiγdaqui: :

sirγuljin-u ülei jogei-yin bal kiged sine saran:

öčügüken öčügüken nemegsen-iyer **dügürün** bui: :

(324) noyan kümün **irgen-i** ülü qoruγulun:

törü yosuγar alban-i γubčiγdaqui: :

sala modun-ača küji-yin küčün:

olan čiburibasu modun-i qoqiran bui: :

Субашидын маш эртний монгол эх



Бүр хожуу үед цахар гэвш Лувсанцүлтэмийн орчуулгаар бол:

(323) Алимад олноос татах их сан байгуулан өсгөхөд
Асар нэгмөсөн хураалгүй цувуулбал арвин болно.
Адилтгавал шоргоолж нүх малтах, зөгий бал хураах ба
Арвитах шинийн сар өчүүхэн нэмсээр дүүрэх мэт.

(324) Тэргүүлэгч ихэс ноёд олонд хор үл болохыг
Тэгш хэрээр бодож татвар албыг бүтээтүгэй.
Тэр нь сал модны шимийг хүжинд холивол сайн болох боловч
Түүнийг нэн их авбал мод нь хатаж одохтой адил.